

“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Цаг: 18:10 -20:40

Байршил: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө-17, “Блю ский” зочид буудлын 3 давхар, “Даймонд” танхимд

Хурлын дарга: Ломбын Эрхэмбаяр

Хурлын нарийн бичгийн дарга: Дашцэрэнгийн Наранцэцэг

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо: 270

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо: 161,454,115 ширхэг.

Хурлын ирц: 80,73%

Тэмдэглэл:

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Гүйцэтгэх удирдлагаас хурлын даргыг томилсон бөгөөд үүсгэн байгуулагч /хувьцаа эзэмшигч/ хурлыг даргалж байгаа тухай, хурал зарласан тухай Гүйцэтгэх захирлын тушаал, хурлын материалыг Санхүүгийн Зохицуулах Хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын журмын дагуу 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр, 04 дүгээр сарын 06-ны өдөр сонин болон телевизээр нийтэд зарласан, мөн 2019 оны 03 сарын 27-ны өдөр брокер, дилерийн компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан талаар танилцуулав. Түүнчлэн энэхүү хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчийг тогтоосон бүртгэх өдрийг 2019 оны 04-р сарын 08-ны өдрөөр тогтоосон болохыг танилцуулав.

Мөн хурлын дарга хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулав. Хурлаар хэлэлцэх асуудал бүрийг танилцуулсны дараа асуулт, хариулт, санал шүүмжлэлээ хэлэхээр шийдвэрлэв. Нэг хувьцаа эзэмшигч 1 асуудлаар 3 минутын хугацаанд санал хэлэх, асуулт асуух нь зүйтэй гэж үзсэнийг хуралд оролцогчид 100% дэмжиж хурал эхлэв.

ХУРЛААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

1 дэх асуудал: “Түмэн шувуут” ХХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Гүйцэтгэх захирлын тайланг Ж.Болд танилцуулав.

2 дахь асуудал: Ногдол ашгийн тухай Л.Эрхэмбаяр танилцуулав.

3 дахь асуудал “Түмэн шувуут” ХХК-ийг ХК болгон хэлбэрийг өөрчлөх, “Түмэн шувуут” хувьцаат компанийн дүрмийг батлах тухай Л.Эрхэмбаяр танилцуулав.

4 дэх асуудал: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн мэдээллийг танилцуулав.

5 дахь асуудал: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай тогтоолын төслийг танилцуулав.

АСУУЛТ, ХАРИУЛТ, САНАЛ

Хувьцаа эзэмшигч Мөнхбаяр: 5 тэрбум төгрөг Голомт банкинд байгаа гэж байна. Төлөвлөсөн ажил саатаж байгаа тул энэ мөнгийг уян хатан байдлаар эдийн засгийн үр ашигтай зүйлд хийж болох уу?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Улирлын онцлогоос шалтгаалан аливаа барилгын ажил дулаарахаар эхэлдэг. Иймээс бид барилгаа барьж эхлээгүй байж тоног төхөөрөмжөө захиалж болохгүй юм аа. Нэгэнт төлөвлөсөн бүтээн байгуулалт, газар тариалан болон барилгын ажил эхлэх хүртэл бид өөрийн компанийн дансанд хадгалснаас банкинд байршуулсан нь зүйтэй гэж үзсэн. Банкны хадгаламжийн хугацаа нь одоо 05 сарын 23-нд дуусна. Хүү нь нийтдээ 140 сая орчим болж байгаа юм.

Хувьцаа эзэмшигч Баясгалан: Санхүүгийн тайланд бүтээгдэхүүний өртөг 2019 онд өссөн байна. Эндээс харахад ашигтай бус алдагдалд орохоор харагдаж байна. Үүнийг тайлбарлана уу.

Ерөнхий нягтлан бодогч Н.Должинсүрэн: СТОУС-41 стандартын дагуу тайлагнахад Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг анхдагч хүлээн зөвшөөрөлтийн үеийн олз гарзыг бүртгэж, өртөг өсөж, бусад ашиг дээр тайлагнагдсан юм.

Хувьцаа эзэмшигч Баясгалан: Аудитын хороо байгуулагдах уу?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороог байгуулнаа.

Хувьцаа эзэмшигч Баярмаа: Өндөгний импортын зах зээлийн тоог хэмжээг бууруулах тал дээр хэрхэн ажиллаж байна вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Манай компанийн үйлдвэрлэлдээс 3 дахин их өндөг импортоор орж ирж байна. Импортоор орж ирж байгаа өндөгний тоо хэмжээг бууруулах тал дээр төр засгаас ч мөн дэмжсэн бодлого хэрэгжүүлж байна. Энэ нь эрчимжсэн мал аж ахуйг дэмжсэн үндэсний хөтөлбөр батлагдсан явдал юм. Энэ хөтөлбөрийн дотоодод үйлдвэрлэх бүтээгдэхүүний жагсаалтад өндөг орсон байдаг. Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр өндөгний импортыг 90% багасгах боломжтой болно.

Хувьцаа эзэмшигч Баярмаагийн санал: Бүтээгдэхүүнээ худалдан борлуулах нэрийн дэлгүүр нээвэл их зүгээр санагдаж байна.

Л.Эрхэмбаяр: Ямар ч байсан нэг нэрийн дэлгүүр нээх төлөвлөгөөтэй байгаа. Бусад дэлгүүрүүдийн орлогыг бууруулах сул талтай байгаа.

Хувьцаа эзэмшигч Эрдэнэбаатар: ТУЗ-ийн хороодын мэдээллийг ямар шугамаар хүргэх вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: ТУЗ-өөс гарч буй аливаа шийдвэрийг бид нийт хувьцаа эзэмшигчдэдээ нээлттэй байдлаар мэдээллэнэ. Та бүхэн манай компанийн www.tumenshuvuut.mn гэсэн албан ёсны вэб хуудас руу орж өөрийн цахим шуудангийн хаягаа бүртгүүлснээр мэдээллээ цахим шуудангаар автоматаар авч болно. Мөн манай компанийн болон Монголын хөрөнгийн биржийн сайтаас мэдээллээ авах боломжтой.

Хувьцаа эзэмшигч Эрдэнэбаатар: 2019 оны хэдэн хувьд нь ногдол ашиг тараах вэ?

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Бид 2019 оны татварын дараах цэвэр ашгийн 30 хувийг нийт хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг болгон тараана.

Хувьцаа эзэмшигч Алтан: Хөдөлмөрийн бүтээмж сайн учир ажилчдын цалинг нэмж болох уу?

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Бид өнгөрсөн 2018 оны 11 сард ажилчдынхаа цалинг нийтэд нь 200,000 төгрөгөөр нэмсэн. Цаашид ч нэмэх бодолтой байна. Гэхдээ бид сайн судалгаа хийсний үндсэн дээр шийдвэрлэнэ.

Хувьцаа эзэмшигч Лхагвадоржийн санал: Би БНСУ-д тахианы фермд ажиллаж байсан. Тэнд чанасан өндөгний технологи, системийг харж байсан. Бэлэн чанасан өндөг хийвэл эрэлттэй байх гэж бодож байна. Иймд чанасан өндөгний тоног төхөөрөмж оруулж ирвэл сайн байна.

Хувьцаа эзэмшигч Дашдаваа: Компанийн дүрмийн 15.4 дээр байна. Гүйцэтгэх захирал давхар ажил хийх үү?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Хувьцаа эзэмшигч маань сайн турилгаа хуваалцаж байгаад талархаж байна. Хэсэг залуучууд болсон өндөг худалдаанд гаргасан, хэрэглэгчид төдийлөн дасаагүй, сайн урагшлахгүй байгаа. Миний хувьд зөвхөн “Түмэн шувуут” компанийн төлөө өөрийн бүхий л хүч чадлаа дайчлан ажиллах болно.

Хувьцаа эзэмшигч Дашдаваа: Компанийн дүрмийн 8.5 дээр дийлэнх олонхоор санал хураана гэж байна. Үүнийг сайн тайлбарлахгүй бол зарим хүмүүс ойлгохгүй байх аа?

Хурлын дарга Л.Эрхэмбаяр: Мэдээж нийт саналын 2/3 буюу дийлэнхи олонхийн саналаар эсвэл 50+1 гэсэн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ гэсэн үг.

Хувьцаа эзэмшигч Дашдаваа: Дотоод хяналтын тогтолцооны талаар яаж ажиллах вэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Дотоод хяналт нь хуулийн дагуу явагдана. ТУЗ-ийн дэргэдэх хороогоороо дамжуулан хэрэгжүүлэх болно.

Хувьцаа эзэмшигч Нямдорж: ТУЗ-ийн хараат бус гишүүдийг хэрхэн сонгосон бэ?

Гүйцэтгэх захирал Ж.Болд: Бид олон нийтэд нээлттэйгээр Хараат бус гишүүдийг сонгон шалгаруулах зарыг тавьсан. Компанийн ТУЗ байгуулагдаагүй тул Гүйцэтгэх захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж, нэр дэвшүүлэх хүмүүсийн сонголт хийсэн. Харин энэ хурлаараа хувьцаа эзэмшигч Та бүхэн ТУЗ-ийн гишүүдээ сонгох юмаа.

ХУРЛААС ГАРСАН ШИЙДВЭР БОЛОН САНАЛ ХУРААЛТЫН ДҮН

1 дэх асуудлаар:

1. Дараах шийдвэр гаргав:

1. “Түмэн шувуут” ХХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Гүйцэтгэх захирлын тайланг батлав.
2. Тус компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг шинээр байгуулагдах Төлөөлөн удирдах зөвлөлд, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д тус тус үүрэг болгов.

2. Нэг дэх асуудлаарх санал хураалтын дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
200,000,000	161,454,115	200,000,000	161,454,115	200,000,000	161,454,115
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
160,869,866	99.99%	0	0%	11,525	0.01%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь зөвшөөрч, 0% нь татгалзаж, 0.01% нь түдгэлзэв.

2 дахь асуудал:

1. Хоёр дахь асуудлаар дараах шийдвэр гаргав:

1. Тус компанийн 2018 оны үйл ажиллагааны үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийн талаарх Гүйцэтгэх захирлын танилцуулгыг сонсож, тус компанийн 2018 оны ашгийн үр дүнгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.
2. Энэхүү тогтоолыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлж, олон нийтэд мэдээллэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.

2. Хоёр дахь асуудлаар саналх хураалтын дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Нийт саналын эрхтэй хувьцаа	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа
200,000,000	161,454,115	200,000,000	161,454,115	200,000,000	161,454,115
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
160,858,762	99.99%	19,609	0.01%	3,020	0.00%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь зөвшөөрч, 0.01% нь татгалзаж, 0.00% нь түдгэлзэв.

3 дахь асуудал:

1. Гурав дахь асуудлаар дараах шийдвэр гаргав:

1. “Түмэн шувуут” ХХК нь нийт гаргасан энгийн хувьцааныхаа 25 хувийг Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд амжилттай арилжаалж, нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилснийг дурдаад тус Компани нь нэг бүр нь 20 (хорь) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 200,000,000 (хоёр зуун сая) ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 4,000,000,000 (4 тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг баталгаажуулав.
2. “Түмэн шувуут нээлттэй хувьцаат компанийн дүрэм”-ийг уг тогтоолын хавсралтаар батлав.
3. Шинэчилсэн Дүрмийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн Зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д, Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад тус тус үүрэг болгов.

2. Гурав дахь асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
------------	------------	------------

Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
160,868,451	99.99%	2440	0.00%	10,500	0.01%

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99.99% нь зөвшөөрч, 0.00% нь татгалзаж, 0.01% нь түдгэлзэв.

4 дэх асуудал:

1. Дөрөв дэх асуудлаар дараах шийдвэр гаргав:

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгов:

1.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1. Ломбо овогтой Эрхэмбаяр
- 1.1.2. Балай овогтой Тунгалаг
- 1.1.3. Жигжид овогтой Болд
- 1.1.4. Эрхэмбаяр овогтой Баяржаргал
- 1.1.5. Эрдэнэчулуун овогтой Жаргалхүү
- 1.1.6. Цэрэннадмид овогтой Рэнчинсэнгээ

1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1.2.1. Цэдэв овогтой Наран-Учрал
- 1.2.2. Отгон овогтой Мөнхжаргал
- 1.2.3. Цэгмэд овогтой Лут-Очир

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хурлыг 2019 оны 05 дугаар сард багтаан хуралдуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зэрэг компанийн засаглалын журмуудыг баталж, ТУЗ-ийн дарга, түүний дэргэдэх хороодыг байгуулах ажлыг шинээр сонгогдсон гишүүдийн оролцоотойгоор зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.
3. Хууль тогтоомж, компанийн дүрэм, компанийн засаглалын журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгов.
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинээр сонгогдсон ердийн болон хараат бус гишүүдийн талаархи мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д, уг тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад үүрэг болгов.

2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох тогтоолын төслийг батлах асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115

Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
160,870,891	99.99%	0	0%	10,500	0.01%

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал хураалтын дүн:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Ломбо Эрхэмбаяр	166,128,464	17.21%
Балай Тунгалаг	161,300,215	16.71%
Жигжид Болд	163,839,805	16.97%
Эрхэмбаяр Баяржаргал	160,967,913	16.68%
Эрдэнэчулуун Жаргалхүү	160,937,003	16.67%
Цэрэннадмид Рэнчинсэнгээ	152,114,946	15.76%

Үүнээс: Л.Эрхэмбаяр, Б.Тунгалаг, Ж.Болд, Б.Баяржаргал, Э.Жаргалхүү, Ц.Рэнчинсэнгээ нар сонгогдов.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар өгсөн санал хураалтын дүн:

Овог нэр	Санал өгсөн эрх	Саналын хувь
Цэдэв Наран-Учрал	155,553,442	32.23%
Отгон Мөнхжаргал	153,886,291	31.88%
Цэгмэд Лут-Очир	151,395,206	31.37%
Самбуу-Ендон Насанжаргал	840,943	0.17%
Батцогт Манлайбаатар	215,766	0.04%
Ядамсүрэн Өлзийболд	20,752,525	4.30%

Үүнээс хамгийн олон санал авсан Ц.Наран-Учрал, О.Мөнхжаргал, Ц.Лут-Очир нар сонгогдов.

5 дахь асуудал:

1. Тав дахь асуудлаар дараах шийдвэр гаргав:

1. “Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллыг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлав. (*Хавсралтаар: Ердийн болон хараат бус гишүүдийн цалин хуралд оролцсон байдлаар тооцох ба ТУЗ-ийн 1 удаагийн хуралд оролцоход гишүүн тус бүр 500,000 төгрөг байхаар батлав.*)
2. Түүнчлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ж.Болд)-д үүрэг болгов.

2. Энэ асуудлаар ямар нэгэн санал шүүмжлэл хэлсэнгүй.

3. Энэ асуудлаар санал хураасан дүн:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115	Нийт саналын эрхтэй хувьцаа 200,000,000	Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа 161,454,115
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
160,757,385	99,92%	124,006	0,08%	0	0%


Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 99,92% нь зөвшөөрч, 0,08% нь татгалзаж, 0% нь түдгэлзэв.

Хурлын дарга Л.Эрхэмбаяр Хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 20:40 цагт хурал өндөрлөв.

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:

 Л.ЭРХЭМБАЯР

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

 Д.НАРАНЦЭЦЭГ